

ГЯЯ-НЫ ТҮР ДАГАЖ ЯВАХ ДҮРЭМ

Нэгдүгээр бүлэг. Нийтийн товчоо

Нэгдүгээр зүйл. ГЯЯ болвоос гадаадын улстай харилцан холбогдсон элдэв хэрэг зүйлийг эрхэлж тус улсын хууль дүрэм, гадаад улстай тогтоосон гэрээ бичиг ба, олон улсын хоорондох дипломатын албан хаагчдын харилцдаг нийтийн хууль дүрмийн ёсоор явуулмуй.

Хоёрдугаар зүйл. Тус яамны хэргийг захиран удирдах-ын тул, сайд эрхэлсэн түшмэл нижгээд орон байх бөгөөд, сайдыг улсын бага хурлаас сонгон тогтоох ба, эрхэлсэн түшмэлийг Засгийн газраас батлан тогтоосон ёсоор явуулмуй.

Гуравдугаар зүйл. ГЯЯ нь Ерөнхий Өрнөд Дорнод хэмээх гурван хэлтэс байгуулмуй.

Дөрөвдүгээр зүйл. Тус яамны харъяат албаны газруудыг захирч мөн тэдний албан хаагчдын орон тоо ба, аливаа хэргийг өөр өөрийн тусгай тогтоосон дүрэм зааврын ёсоор явуулмуй.

Хоёрдугаар бүлэг. Албан хаагчдын тухай

Тавдугаар зүйл. ГЯЯ-ны ерөнхийлөн захирах сайдын эрхлэх хэрэг нь:

Нэг. Тус яамны хэлтсүүд ба, харъяат захирах газруудын явуулан буй хэргийг ерөнхийлөн хянамуй.

Хоёр. ГЯЯ-наа холбогдох хууль дүрэм гэрээ бичгийг ёсоор явуулж буй үгүйг хянах ба ёсоор явуулах арга сүвэгчилмуй.

Гурав. Улсын Их, бага хурал ба, Засгийн газрын тогтоолуудыг ёсоор гүйцэтгүүлэх санааг сүвэгчилмуй.

Дөрөв. Мөн яамнаа холбогдох хууль дүрэм ба, гэрээ бичгийн дотор залруулах өөрчлөх зүйл буй аваас зохих газраа саналыг илтгэн явуулж шинэ гаргах хууль дүрэм ба, гэрээ бичиг тогтоох явдлыг батлан тогтоолгох зэргээр гүйцэтгүүлэхээс гадна жич аливаа хэргийг гадаадын боловсорсон улсын ёсоор сайжруулан явуулахыг хичээн оролдмуй.

Тав. Тус яамны харъяат газрууд, өөр өөрийн хэргийг хэрхэн явуулах тухай ба, дүрэм зааварт оролцсонгүй хэргүүдэд зохих заавар гаргаж журамлан дагаж шийтгүүлмуй.

Зургаа. Тус яам ба харъяат газруудын албан хаагчдын дотроос Засгийн газраас томилох орон тоог мэдүүлж тогтоолгохоос гадна, бусад албан хаагчдыг томилон авах ба, шилжүүлэх, чөлөө олгох, албанаас халах зэргийг гүйцэтгүүлмуй.

Долоо. Тс яамны хэлтэсүүд ба, харъяат газруудын албан хаагчдын заалдсан буюу, хэрэг саатуулсан дээш явуулсан зэрэг хэргийг тушаалын эрх хэмжээний ёсоор шийтгэж чухал учир тохиолдвоос уламжлан зохих газраа явуулж шийтгүүлмуй.

Найм. Найрамдсан гадаад улсад тус улсаас суулгасан элчин сайдуудад тусгай дүрэм заавар олгох ба, улс төрд холбогдолтой нууц хэрэг зүйлийг аль болох аргаар түргэн нэвтрүүлж гүйцэтгүүлэхээс гадна олон гадаад улсын байдал төлөвийг сайнаар мэдэхийг хичээн оролдмуй.

Ес. Тус улсад найрамдсан гадаад улсаас суулгасан Элчин сайд Консул нарыг хүндэтгэн хүлээн авахуулах, зочлох, улс төрд чухал холбогдолтой харилцваас зохих дипломатын хэрэг зүйлийг сайдын хувиар ам буюу ноот зэрэг бичгээр харилцаж гүйцэтгүүлмуй.

Арав. Тус яам ба харъяат газруудын орлого зарлагын төсөвлөсөн дансыг улсын бүх орлого, зарлагын комисст оруулахын инар хянан тогтоомуй.

Арван нэг. Аливаа цахилгаан мэдээгээр олон газраас ирсэн ба, мөн олон газар явуулах хэргүүдийг эрхэлмуй.

Арван хоёр. Гадаад улстай тогтоосон гэрээ бичиг ба нууц чухал хэргийн бичгүүдийг тусгаар хадгалмуй.

Арван гурав. ГЯЯ-ны тамгийг хадгалмуй.

Зургадугаар зүйл. Эрхэлсэн түшмэлийн гүйцэтгэх хэрэг нь

Нэг. Харъяат сайдын эрхлэх хэрэгт туслан гүйцэтгэлцмуй.

Хоёр. Харъяат сайдын чөлөө цагт яамны тамга хэргийг хамааран шийтгэмуй.

Гурав. Сайдаас даалгасан хэргүүдийг гүйцэтгэх ба, мөн яамны хэлтсүүдийн хэргийг хянахаас гадна аливаа бичгийн хэргийг удаашруулахгүй түргэн гүйцэтгүүлэхийг оролдмуй.

Дөрөв. Бичээч зарлага, галчийн зэрэг албан хаагчдыг шууд томилох ба халмуй.

Тав. Тус яамны аливаа орлого, зарлагыг уг төсөвлөсөн ёсоор гүйцэтгэн буй үгүйг хянаж сайдад мэдэгдэмуй.

Зургаа. Тус яамны тэмдгийг хадгалмуй.

Долдугаар зүйл. Хэлтсийн эрхэлсэн түшмэдийн эрхлэх хэргүүд нь

Нэг. Харъяат хэлтсийн бүхий л хэргийг эрхэлж дүрэм заавар ба сайдын тушаалын ёсоор явуулмуй.

Хоёр. Өөр өөрийн хэлтсийн явуулах ба явуулсан хэргүүдийг тодорхой мэдэж байваас зохимуй.

Гурав. Харъяат хэлтсүүдийг албан хаагчдад тус тусын гүйцэтгэх хэргүүдийг хуваан ноогдуулж хэрхэн гүйцэтгэж буйг хянамуй.

Дөрөв. Аливаа хэргийг хууль дүрэмд нийлүүлэн үзэж хэрхэн шийтгэвээс болох саналыг төлөвлөн улмаар зохигчдод үзүүлэн шийдвэрийг авч шийтгэх бөгөөд, хэргийг удаашруулахгүй түргэн гаргахыг ямагт хичээн оролдмуй.

Тав. Дагаж шийтгүүлэн буй дүрэм зааварт бүрхэгдсэн буюу дутагдсан зүйлүүд ба тус улсын хэлтсээс эрхлэн явуулж бүхий хэргүүдийг хэрхэн сайжруулваас болох арга зэргийг урьдаас төлөвлөн харъяат сайдад мэдүүлмуй.

Зургаа. Харъяат хэлтсийн бичгүүдийг эмхтэй цэгцтэйгээр болгож тухай бүр уг зүйл ангид нийлүүлэн хадгалмуй.

Наймдугаар зүйл. Хэлтсүүдийн туслах түшмэл нар болвоос мөн хэлтсийн эрхэлсэн түшмэлийн аливаа явуулах хэрэгт туслалцахаас гадна сайдын тушаалаар тус хэлтсийн нэгэн зүйл хэргийг эрхэлж болмуй.

Есдүгээр зүйл. Нягтлан бодох түшмэлийн эрхлэх хэргүүд нь

Нэг. Харъяат яамны зарлагыг төсөвлөсөн дансны ёсоор зарцуулах мөн яамны төсөвлөсөн данс ба бүхий л орлого зарлага хөдлөх үл хөдлөх хөрөнгийн тайлан дансуудыг дүрэм зааврын ёсоор үйлдэх хэргийг гүйцэтгүүлэхээс гадна аливаа орлого зарлагын тухай холбогдох данс бичгүүдийг зүйл ангиар ялган салгаж тусгаар хадгалмуй.

Хоёр. Тус яамны харъяат газруудын төсөвлөсөн ба тайлан дансыг хянаж явуулмуй.

Гурав. Аливаа олон газраас хүргүүлж ирсэн мөнгийг байцаан хурааж няравт хадгалуулах зохих газар хүргүүлэх явдлыг гүйцэтгүүлмүй.

Дөрөв. Тус улсын хязгаар нэвтрүүлэх ба мөн хязгаарын дотор явах, суух дотоод гадаадын харъяат нарт олгуулах паспорт бичиг ба үнэмлэх хамгаалах зам явах бичгийн эхүүдийг хэвлүүлэн бэлтгэх бүртгэж тайлан данс үйлдэх хэргийг эрхэлмүй.

Аравдугаар зүйл. Нярав болвоос тус яамны мөнгө хадгалахаас гадна аливаа мөнгө хүргүүлэх яамны зарлагыг төсөвлөсөн дансны ёсоор зарцуулах явдлыг заавар тушаалын ёсоор гүйцэтгэлцэж тусгай гарын данстай байхын дээр мөн яамны эдлэл, хогшил, орон сав зэргийг хямгатайгаар хадгалах засаж сайжруулах зэргийг эрхэлмүй.

Гуравдугаар бүлэг. Хэлтсүүдийн эрхэлвээс зохих хэргүүдийн тухай

Арван нэгдүгээр зүйл. Ерөнхий хэлтсийн эрхлэх хэргүүд нь

Нэг. Харъяат яамны нэрээр харилцах ба зарлаваас зохих бөгөөд бусад хэлтэст холбогдохгүй хэргүүдийг эрхэлмүй.

Хоёр. Аливаа бичгийг хүлээн авч дансанд тэмдэглээд зохих хэлтсүүдэд хуваан тушааж аливаа шийтгэн гарах бичгүүдийг явуулж тус хэлтсийн эрхлэх данс харааг хадгалмүй.

Гурав. Дагаж явбаас зохих хууль дүрэм ба харъяат яамны тушаал зарлал зэргийг эмхлүүлэн зохихыг нь зарлаж данснаа тэмдэглэн хадгалмуй.

Дөрөв. Тус яамны харъяат газруудыг байгуулж мөн газруудын явуулж бүхий албыг ерөнхийлөн хянаж баймуй.

Тав. Тус яамнаа буюу орчуулагчийн орон тоо үгүй бусад хэлтэст харъяалагдах гадаадын үсгийн бичгүүдийг монголчлон, монгол үсгийн бичгүүдийг гадаадын үсгээр орчуулж баймуй.

Зургаа. Тус яам ба харъяат газруудын албан хаагчдыг бүртгэж баймуй.

Долоо. Тус яамны албан хаагчид оноосон тушаасан албыг шударгаар хурдлан явуулж буй үгүй ба харилцан бичиглэхийг хир зэргээр хомсотгох явдлыг ерөнхийлөн хянаж баймуй.

Найм. Тус яамны орлого зарлагын дансыг төсөвлөн зохиомжуй.

Ес. Тус яам ба харъяат газруудын орлого, зарлагын тайлан данс ба хөдлөх үл хөдлөх хөрөнгийн тайлан дансыг гүйцэтгүүлмүй.

Арав. Харъяат яам ба мөн яамны нэрээр бусад олон газруудад хураасан бүхий л орлогыг байцаан хурааж дансанд оруулан зохих газраа хүргүүлж баймуй.

Арваннэг. Мөн яамны эд хогшил ба орон савыг ариун цэвэр зүй зохистойгоор агуулж сайжруулх явдлыг эрхэлмүй.

Арван хоёр. Гадаад улсад албаны ба хувийн хэргээр одох тус улсын харъяат нарт паспорт бичиг олгох хэргийг эрхэлмүй.

Арван гурав. Мөн яам ба бусад олон газруудаас тус улсын хязгаарын дотор суух явах ба хязгаараас гарах гадаад дотоодын харъяат нарт олгуулах хамгаалах үнэмлэх паспорт зам явах бичгийн эхүүдийг төсөвлөн хэвлүүлж бэлтгэх, мөн эхүүдийг тус яамны эрхлэх хэлтсүүд ба бусад олон газраа хүргүүлэн олгуулах мөн хүргүүлсэн эхүүдээс олгуулсан үлдсэн зэргийг бүртгэн байцаах хэргийг эрхлэн гүйцэтгүүлмүй.

Арван дөрөв. Тус улсын хязгаарын дотор суугаа гадаад улсын харъяат хүн иргэний тоо хичнээн болох ба бас ч тэд нарын аж ахуйн байдал ямар болох зэргийг харъяат газар орон нутгийн захиргааны газруудаас тодорхойлуулж аль аль

улсын харъяат хэд хэдэн хүн иргэн сууж ямар аж үйлдвэр хийж буйг мэдэх арга сүвэгчилмүй.

Арван тав. Тус улсын хязгаар нэвтэрч одох гадаад улсын харъяат нарын паспорт бичигт виз нэмэн дарж хязгаар нэврүүлэх хэргийг эрхэлмүй.

Арван зургаа. Гадаад улстай холбогдсон тус улсын хил хязгаарын газрыг тогтоож батлан хамгаалах явдлыг Засгийн газар мэдүүлэн тогтоолгож эрхлэх газруудтай хавсран гүйцэтгүүлмүй.

Арван хоёрдугаар зүйл. Өрнөд хэлтэс болвоос Европ, Африк, Австрали тивийн олон улс ба Евротой хязгаар нийлсэн Ази тивийн умар этгээдэд бүхий Түрц, Перс /Иран/, Афганистан зэрэг олон гадаад улстай харилцан холбогдсон эл хэргийг эрхэлмүй.

Арван гуравдагаар зүйл. Дорнод хэлтэс болвоос Думдад иргэн улс ба Түвэд, Тагна Тува, Япон, Америк улстай харилцан холбогдсон эл хэргийг эрхэлмүй.

Арван дөрөвдүгээр зүйл. Арван хоёрдугаар, арван гуравдугаар зүйлд дурдсан олон гадаад улс лугаа Өрнөд, Дорнод хоёр хэлтсийн харилцваас зохих хэргүүд нь:

Нэг. Харъяат хэлтсүүд өөр өөрийн харилцваас зохих улсаас тус улсын хязгаарын дотор суух явах ба, хязгаар гарах хүн иргэний шударга самууныг магадлан байцаалгаж хамгаалах үнэмлэх зам явах бичиг олгуулах гадаад улсын харъяат нараас хязгаарын дотор агуулан суулгах эсэх ба мөн хязгаарт оруулах эсэх зэрэг хэргийг тусгай дүрмийн ёсоор эрхлэн гүйцэтгүүлмүй.

Хоёр. Тус улсын хязгаарын дотор суугаа өөр өөрийн харилцах гадаад улсын харъяат нараас цаазалсан зүйлийг зөрчих зэргээр харшлалтай хэрэг өдүүлэгчид хэрэв буй ахул цээрлүүлэн шийтгүүлж устгахыг хичээн оролдмүй.

Гурав. Тус тусын харилцаваас зохих гадаад улстай аливаа гэрээ бичиг тогтоох найрамдах эсэргүүцэх цахилгаан мэдээ шуудан бичиг нэвтрүүлэх агаарын онгоц ба, төмөр усан зам нэвтрүүлэх эрдэм соёл ба худалдаа аж үйлдвэрийн тухай холбогдох хэрэг зүйлийг эрхлэх газруудтай зөвлөлдөн төлөвлөж зохих газраа мэдүүлж тогтоолгон батлуулах ба, тусгай гэрээ дүрмийн ёсоор явуулах хэргийг эрхэлмүй.

Дөрөв. Мөн өөр өөрийн харилцах улсуудаас тус улсад дагаар орохыг хүсэгчдийн хэргийг тусгай дүрмийн ёсоор явуулмүй.

Тав. Өөр өөрийн харилцваас зохих улсын дотроос найрамдсан улсад тус улсаас суулгах элчин сайдууд ба, харъяат албан хаагчдын орон тоо цалин хэрэгслийг батлан тогтоолгох мөнхүү элчин сайдуудад заавар дүрэм олгох, гадаад улстай харилцах эл хэрэг зүйлийг уламжлан гүйцэтгүүлэх элдэв сонин сэтгүүл мэдээ харилцан нэвтрүүлж гадаад дотоодын байдлыг мэдэж байх хэргийг эрхэлмүй.

Зургаа. Мөн найрамдсан улсаас тус улсад суулгах элчин консулуудыг тушаалын газраа ирсэн тухай бүр Засгийн газартаа хүлээн авахуулах баяр ёслол тохиолдох өдөр зочлох явдлыг уламжлан гүйцэтгүүлэхээс гадна аливаа харилцваас зохих хэрэг зүйлийг эрхлэн гүйцэтгүүлмүй.

Долоо. Өөр өөрийн харилцваас зохих гадаад улсын харъяат хүн иргэний харилцан холбогдсон иргэний ба эрүүгийн хэргийг харъяат орон нутгийн шүүх таслах газраа шилжүүлэн шийтгүллмүй.

Арван тавдугаар зүйл. Харьяат хэлтсүүдийг хэлтсийн эрхэлсэн түшмэд захирч өөр өөрийн хэлтсийн эрхэлвээс зохих хэрэг зүйлийг хууль дүрэм тогтоол заавар буюу гэрээ бичгийн ёсоор гүйцэтгүүлэхээс гадна гадаад улстай харилцах аливаа хэргийг олон улсын харилцан бүхий хууль дүрмийг баримтлан явуулахыг хичээн оролдмуй.

Арван зургадугаар зүйл. Нэг хэлтэс дангаараа эрхлэж үл болох хэргийг зохих хэлтэс нар хамт гүйцэтгэмүй.

Арван долоодугаар зүйл. Тус яамнаас аливаа шийтгэн гаргах бичгүүдэд сайд эрхэлсэн түшмэл нар гарын үсэг зурах ба, хуудсанд яамны эрхэлсэн түшмэл гарын үсэг зурж тус тусын тамга тэмдэг дарж явуулмуй.

Арван наймдугаар зүйл. Тус яам дангаараа тойровч шийтгэн явуулахад тулгуурлахгүй буюу, жич шинэ тогтоох дүрэм зэргүүдийг Засгийн газар мэдүүлэн батлуулах зэргээр тогтоолгомүй.

Дөрөвдүгээр бүлэг. Тайлан ба байцаах тухай

Арван есдүгээр зүйл. Тус яам аливаа зүйлийг төсөвлөсөн дансны ёсоор гүйцэтгэвээс зохимуй.

Хорьдугаар зүйл. Тус яам ба харьяат газруудын орлого зарлагын тайлан данс ба, төсөвлөсөн данс үйлдэх явдлыг нягтлан бодох дүрмийн ёсоор гүйцэтгүүлмүй.

Хорин нэгдүгээр зүйл. Харьяат яамны хэлтсүүд ба, бусад харьяалагдах газруудыг сайд өөрөө буюу зохих хүмүүсийг томилон аливаа хэргээ хэрхэн явуулж буйг хянан байцааж байваас зохимуй.

Хорин хоёрдугаар зүйл. Хэлтсүүд ба газрууд өөр өөрийн явуулсан бүтээсэн явуулахыг завдан буй хэргүүдийг тусгай дүрэм зааврын ёсоор тогтоосон цаг тухайд мэдүүлэн ирүүлж байваас зохимуй.

Монгол Улсын арван долоодугаар он гурван сарын арван найман